

III БҮЛЭГ. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нэг.Зорилго

Энэхүү зөвлөх үйлчилгээний зорилго нь Монгол Улсад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон харилцааг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлдэг бие даасан байгууллагын эрх зүйн байдлыг тодруулж, олон улсын ижил зохицуулах байгууллагын тогтолцоотой харьцуулах, бусад төрийн байгууллагад хамаарах чиг үүргийн давхардлыг арилгах замаар бие даасан зохицуулах байгууллагын хуулийн этгээдийн статус, эрхзүйн байдал, чиг үүргийн хэрэгжилтийг эрх зүйн аргаар сайжруулах хувилбар, саналыг дэвшүүлэхэд оршино.

Хоёр. Үндэслэл

Монгол Улсын Их Хурал “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль”-ийг 2005 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр баталж, Санхүүгийн зохицуулах хорооны үйл ажиллагааны эрх зүйн үндэс бий болж, банкнаас бусад санхүүгийн зах зээлийн нэгдсэн зохицуулалтад шилжих анхны нөхцөл бүрдэж хөрөнгийн зах зээл, даатгал, банк бус санхүүгийн байгууллага, хадгаламж зээлийн хоршоодын үйл ажиллагааны нэгдсэн хяналт зохицуулалтыг бий болгосон.

Улмаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуульд 2019, 2021, 2022 ондуудад орсон нэмэлт, өөрчлөлтөөр үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгчийн үйл ажиллагаа, үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа, виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн үйл ажиллагаа, технологид суурилсан санхүүгийн шинэ бүтээгдэхүүн, мөнгөн зээлийн үйл ажиллагаа, уул уурхайн бүтээгдэхүүний бирж, биржийн арилжааны зуучлагч /брокер/-ын үйл ажиллагаануудыг хянаж, зохицуулах чиг үүргүүд шинээр нэмэгдсэн.

Технологийн хурдтай хөгжлийн үр дүнд санхүүгийн зах зээл эрчимтэй өөрчлөн шинэчлэгдэж, зохицуулах байгууллагаас инновацыг дэмжсэн, түргэн шуурхай, уян хатан, хүртээмжтэй, оновчтой зохицуулалтыг шаарддаг бол, нөгөө талаар эдгээр зохицуулалтыг хийх байгууллагын эрх зүйн орчин хангалттай бүрдсэн эсэх, бие даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулах нөхцөл хангалттай эсэхийг тодорхойлох хэрэгцээ үүсдэг.

Түүнчлэн улс орон санхүүгийн салбарын зохицуулах байгууллагын эрх зүйн байдлыг харилцан ялгаатай тодорхойлсон байдаг бөгөөд тэдгээрийн ялгаатай байдлын давуу болон сул талыг харьцуулан судалж, үнэлэх замаар Монгол Улсын санхүүгийн зохицуулах байгууллагын эрх зүйн байдалд дүн шинжилгээ хийх, уг салбарын хөгжилд түлхэц үзүүлэхийн тулд зохицуулагч байгууллагын бүтэц, зохион байгуулалт болон түүний бие даасан, хараат бус байдал цаашид анхаарах шаардлагатай асуудлын талаар зөвлөмж, эрх зүйн судалгаа шаардлагатай байна.

Гурав. Зөвлөх үйлчилгээний ажлын хамрах хүрээ, хийж гүйцэтгэх ажил

3.1.Монгол Улсын санхүүгийн зохицуулах байгууллагын эрх зүйн байдлыг тодруулах, хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн судалгааны ажлыг холбогдох хуульд заасан бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд нийцүүлэн дараах сэдвүүдийн хүрээнд цогц судалгааг гүйцэтгэнэ. Үүнд:

3.1.1. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны дүрэм, зохицуулалтад хамаарах санхүүгийн үйлчилгээг зохицуулсан хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд онолын болон олон улсын эрх зүйн харьцуулсан судалгааг хийж, санхүүгийн зохицуулах байгууллагын гүйцэтгэх чиг үүрэг, зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэлбэр, механизмуудыг тодорхойлох замаар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн чадамж, түүний бие даасан, хараат бус байдалд үнэлгээ өгөх;

3.1.2. Санхүүгийн зохицуулах байгууллагаас тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл олгох болон бусад хяналт зохицуулалтын чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэрт хамаарах бүрэн эрхийн ач холбогдол, давуу талыг тодруулах замаар одоогийн Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хороонд олгогдсон бүрэн эрх хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд хангалттай хүрэлцэж буй эсэх, салбарын хөгжилд хэт оролцоотой зохицуулалт эсхүл сул зохицуулалтыг бий болгосон эсэхэд кейс судалгаа хийж, дүгнэлт гаргах;

3.1.3. Санхүүгийн салбарт хамаарах нийт зохицуулалттай этгээд болон түүний бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт, зохицуулалтыг нэгдсэн байдлаар хэрэгжүүлэх боломжтой эсэхийг бусад улс орнуудтай харьцуулан судалгаа хийж, дүгнэлт гаргах;

3.1.4. Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэр /тогтоол/ гаргах эрх зүйн үндэслэл, шийдвэр гаргалтын дарааллыг судалж, нийтээр дагаж мөрдөх эрх зүйн хэм хэмжээг гарган мөрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах, хяналт тавих асуудлыг хууль, эрх зүйн талаас хэрхэн бэхжүүлэх, санал зөвлөмж боловсруулах;

3.1.5. Санхүүгийн зохицуулах байгууллага нь бие даасан үйл ажиллагааг явуулахад төрийн бусад байгууллагын чиг үүргийн давхардал үүсэж байгаа эсэхийг тодруулж, байгаа тохиолдолд үүссэн чиг үүргийн хэрэгжилт, түүний хамрах хүрээг хэрхэн тодорхойлох, арилгах талаар санал боловсруулах;

3.1.6. Санхүүгийн зохицуулах байгууллагын удирдлага, бүрэлдэхүүний томилгоо, зохион байгуулалтын бүтэцтэй холбогдох одоогийн тогтолцоо оновчтой эсэхэд үнэлэлт, дүгнэлт хийх, санал зөвлөмж боловсруулах;

3.1.7. Санхүүгийн зохицуулах хорооны санхүүгийн бие даасан байдлыг хэрхэн хамгаалах, төсөв санхүүгийн хувьд эрх бүхий этгээдээс хараат бус, халдашгүй байх, санхүүгийн шийдвэрийг бие даан гаргах, өмч хөрөнгө шинээр олж авах зэрэг харилцааг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн хамгаалах асуудлыг судалж, дүгнэлт гарган, санал боловсруулах;

3.1.8. Санхүүгийн зохицуулах хороо нь өөрийн зохицуулалтын зарим хэсгийг бусдаар гүйцэтгүүлэх, эсхүл хамтран ажиллах боломжтой эсэхийг тодорхойлох замаар төр, хувийн хэвшилтэй хэрхэн хамтран ажиллах зохистой хүрээг тодорхойлох, төсөл, хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх, судалгааны төв байгуулах боломж нөхцөлийг бүрдүүлэх талаар авах арга хэмжээний санал боловсруулах;

3.1.9. Санхүүгийн зохицуулах хорооны хуулиар олгосон эрх хэмжээ нь зохицуулалтын хүрээний этгээдүүдийг дэмжих, салбарыг хөгжүүлэх, шударга өрсөлдөх боломж, нөхцөлийг бүрэн бүрдүүлж өгч байгаа эсэхэд эрх зүйн дүгнэлт өгөх;

3.1.10. Дээр дурдсан асуудлуудыг судалсны үндсэн дээр Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдал, үйл ажиллагаанд цаашид анхаарах, сайжруулах шаардлагатай асуудлаар зөвлөмж боловсруулах, хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, салбарын бусад эрх зүйн хэм хэмжээнд оруулах өөрчлөлтийн саналыг боловсруулах.

Дөрөв. Судалгаа хийх арга зүй, баримтлах зарчим

Судалгааг гүйцэтгэхэд дараах арга, зарчмыг баримтална. Үүнд:

4.1 Тоон болон чанарын судалгааны арга ашиглах; (Судалгааны зорилго, чиглэлд нийцүүлэн судалгаа хийх тохирсон, үр дүнтэй арга, аргачлалыг сонгож, захиалагчид санал болгож болно.)

4.2 Судалгааг тусгай зөвшөөрөл, энгийн зөвшөөрөл, бүртгэл, эрх, үйлчилгээний төрлөөс хамааруулж, ялгаатай боловсруулах;

4.3 Судалгааны үйл явц, арга аргачлал нь шинжлэх ухаан, онолын үндэслэлтэй байх;

4.4 Судалгааны мэдээлэл, үр дүн үнэн зөв, бодит байх;

4.5 Судалгааг захиалагчийн бүрэн хяналт дор гүйцэтгэх;

4.6 Судалгааны ажлаар цуглуулсан мэдээллийн нууцлалыг хангаж, цахим хэлбэрээр захиалагч талд хүлээлгэх өгөх;

4.7 Судлаачийн мэргэжлийн ёс зүйг баримтлах.

Тав. Ажлын даалгаврын шалгуур шаардлага

5.1. Зөвлөх баг нь дараах шаардлагуудыг хангасан байна.

5.1.1.Зөвлөх үйлчилгээг 5-аас доошгүй эрдэмтэн, судлаачийн бүрэлдэхүүнтэйгээр гүйцэтгэх;

5.1.2.Зөвлөх багийн гишүүд нь эрх зүйч мэргэжилтэй, хууль зүйн салбарт сургалт, судалгааны чиглэлээр мэргэшсэн байна. Гишүүдийн 2-оос доошгүй нь хууль зүйн доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байна. Магистр болон докторын аль нэг зэргээ гадаад улсын их сургуульд судалгаа хийж хамгаалсан бол давуу тал болно.

5.2. Багийн ахлагч нь дараах шаардлагыг хангасан байна.

5.2.1.Хууль, эрх зүйн чиглэлээр мэргэшсэн, хууль зүйн чиглэлээр сургалт, судалгаа явуулсан 10-аас доошгүй жилийн туршлагатай байх;

5.2.2.Эрх зүйн баримт бичиг боловсруулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх аргачлалыг эзэмшсэн байх;

5.2.3.Хууль зүйн доктор ба түүнээс дээш зэрэгтэй байх;

5.2.4.Гадаад хэл дээр мэргэжлийн сэтгүүлд судалгаа бүтээл хэвлүүлсэн, нийтлүүлсэн бол давуу тал болно.

Зургаа. Судалгааны тайлан, тайланд тавигдах шаардлага

6.1.Тайланг цаасан болон электрон хэлбэрээр, холбогдох судалгааны бөглөсөн хуудас, судалгааны тайланд тусгасан бүх дата файлын хамт ирүүлэх;

6.2. Зохицуулалтад хамаарах санхүүгийн үйлчилгээ болон зөвшөөрлийн төрөл чиглэл бүрээр дүгнэлт, анализ гаргасан байх;

6.3.Тайлан нь хэл зүй, найруулгын хувьд ойлгомжтой, эмх цэгцтэй, хуудас, хүснэгт, зургийг дугаарласан, ашигласан баримт бичиг, эшлэлийг дурдсан байх;

6.4.Нэгдсэн тайланг ирүүлэхээс 20-иос доошгүй хоногийн өмнө тайлангийн төслийг захиалагчид ирүүлж, санал заавал авна.

6.6.Гэрээ хүчин төгөлдөр байх хугацаанд зөвлөх үйлчилгээний ажлын гүйцэтгэлтэй холбоотой захиалагчаас шаардсан аливаа мэдээ, мэдээллийг тухай бүр гаргаж өгнө.

6.7.Судалгааны тайлан нь Монгол хэл дээр байх ба дараах хэлбэрээр ирүүлнэ. Үүнд:

6.7.1.Тоон судалгааны мэдээллийг Microsoft Excel;

6.7.2.Судалгааны дэлгэрэнгүй тайланг Microsoft Word;

6.7.3.Товч тайланг Microsoft PowerPoint.

6.8.Судалгааны ажлын тайлан

6.8.1. Зөвлөх баг явцын тайлан гэрээ байгуулснаас хойш сар бүр захиалагчид хүргүүлсэн байна.

6.8.2. Зөвлөх баг эцсийн тайланг гэрээ байгуулснаас хойш 4 сарын дотор судалгааны ажлыг бүрэн гүйцэтгэж хийж гүйцэтгэн захиалагчид хүргүүлсэн байна.

6.9.Судалгаанд ашигласан дагалдах материал, судалгааны эх бичвэрийн файл, санал болгож буй дүн шинжилгээ, тооцооллын аргачлал, загвар, зөвлөмж, бусад холбогдох материал зэргийг ажлын тайланд хавсаргана.

6.10.Ажлын даалгаврын хүрээнд боловсруулсан судалгааны тайлан болон Захиалагчийн цаашид анхаарах, сайжруулах шаардлагатай асуудлын талаарх эрх зүйн зөвлөмж нь олон улсын туршлага, онол арга зүйн болон эрх зүйн баримт бичигт үндэслэсэн байх ба эдгээр нь холбогдох салбарын бодит жишээ, төрийн бодлого, чиглэлд нийцсэн байна.

---oOo---